



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/285

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Буурал овогтой Хүрэлбаатарын Амгаланбаатар (СЭ89021670)-ын эзэмшлийн Хэрлэн сумын 4 дүгээр баг (ХЭРЛЭН), Тариаланчид гудамж Б-17-05 тоот байршилтай гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 700м² газрыг иргэн Сүмбэр овогтой Чулуунбаатарын Хэрлэнбаяр (СЮ85102075)-т 53 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Сүмбэр овогтой Ч.Хэрлэнбаярын эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.


3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Ч.Хэрлэнбаярт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/384 дугаар захирамжийн 4 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



• 231010504